

**УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР**

Огноо: 2020.02.19

**БИЧИГ ХЭРГИЙН МАТЕРИАЛ, ПРИНТЕРИЙН
БОЛОН ХУВИЛАГЧ МАШИНЫ ХОР НИЙЛҮҮЛЭХ
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

**Харьцуулалт/
гэрээний дугаар:БХМПХМХ-2020-02**

Улаанбаатар хот
2020 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020.02.19

Улсын Их Хурлын Тамгын газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **“Бичиг хэргийн материал, принтерийн болон хувилагч машины хорны-БХМПХМХ-2020-02”**-ийг нийлүүлэх үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 03 дугаар сарын 02–ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө Монгол Улс. 14201 Улаанбаатар хот. Төрийн ордон-216Б. Улсын Их Хурлын Тамгын газар. Захиргаа, санхүү үйлчилгээний хэлтэс. Референт Д.Бадамноров. Утас: (976)-51-267142, (976)-99779408 хаягаар ирүүлнэ үү.**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1 Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1 Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2 Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1 Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (a) **Үнийн санал;**
 - (b) **Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;**
 - (в) **Чадварын мэдээлэл /баталгаажуулсан санхүүгийн тайлан/;**
 - (г) **Харъяа татварын хэлтэс, нийгмийн даатгалын хэлтсийн тодорхойлолт;**
 - (д) **Туршлагын мэдээлэл, гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, гүйцэтгэлийн талаархи өмнөх худалдан авагчийн тодорхойлолт;**
 - (e) **Бүтээгдхүүний дээж, дэлгэрэнгүй танилцуулга, техникийн тодорхойлолт;**
- 4. Тогтмол үнэ**

4.1 Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1 Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2 Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.

- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 6.1 Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1 Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2 Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3 Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1 Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт										
ТӨӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> • 2019 оны санхүүгийн тайлан ирүүлэх; • Өр төлбөргүй талаарх харьяа татварын хэлтэс, нийгмийн даатгалын хэлтсийн тодорхойлолт; • Нийлүүлэх бүтээгдэхүүний гарал үүсэл эсвэл албан ёсны борлуулагчийн гэрчилгээний хуулбарыг ирүүлэх • Нийлүүлсэн бүтээгдэхүүний чанарын талаарх өмнөх худалдан авагчийн тодорхойлолт; • Сүүлийн нэг жилийн хугацаанд бичиг хэргийн материал, принтерийн болон хувилагч машины хор нийлүүлсэн ажлын жагсаалт хүснэгтийн дагуу ирүүлэх; <table border="1" data-bbox="469 869 1422 1077" style="width: 100%; border-collapse: collapse; text-align: center;"> <thead> <tr> <th data-bbox="469 869 517 1001">№</th> <th data-bbox="517 869 774 1001">Байгууллагын нэр</th> <th data-bbox="774 869 1038 1001">Нийлүүлсэн бүтээгдэхүүний нэр төрөл</th> <th data-bbox="1038 869 1287 1001">Холбоо барих утасны дугаар</th> <th data-bbox="1287 869 1422 1001">Үнийн дүн</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="469 1001 517 1077"> </td> <td data-bbox="517 1001 774 1077"> </td> <td data-bbox="774 1001 1038 1077"> </td> <td data-bbox="1038 1001 1287 1077"> </td> <td data-bbox="1287 1001 1422 1077"> </td> </tr> </tbody> </table> <ul style="list-style-type: none"> • Үнийн санал; • Нийлүүлэх барааны танилцуулга • Бараа нийлүүлэлтийн хуваарь; • Байгууллагын гэрчилгээний хуулбарыг ирүүлэх; 	№	Байгууллагын нэр	Нийлүүлсэн бүтээгдэхүүний нэр төрөл	Холбоо барих утасны дугаар	Үнийн дүн					
№	Байгууллагын нэр	Нийлүүлсэн бүтээгдэхүүний нэр төрөл	Холбоо барих утасны дугаар	Үнийн дүн							
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: Монгол Улс. 14201 Улаанбаатар хот. Улсын Их Хурлын Тамгын газар Давхар болон өрөөний дугаар: Төрийн ордон-216Б. Захиргаа, санхүү үйлчилгээний хэлтэс. Референт Д.Бадамноров. Утас: (976)-51-267142, (976)- 99779408 Огноо: 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдөр Цаг: 10 цаг 00 минут Хүлээн авах эцсийн хугацаа: Цаг: 10 цаг 30 минут Нээх хугацаа: Цаг: 11 цаг 30 минут</p>										

ТӨӨЗ 6.2**Багц 1:**

Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий бичиг хэргийн материалуудаас бүрдэнэ:

“**Бичиг хэргийн материал-БХМ-2020-02**” тоот харьцуулалтын тендер.

1. Бал үзгэн /1,0/
2. Бал тосон /0,5/
3. Бичгийн тавиур /босоо, төмөр/
4. Бичгийн эрвээхэй хавчаар /том/
5. Бичгийн эрвээхэй хавчаар /жижиг/
6. Наадаг цаас /өнгөт/
7. Өнгийн цаас /А4 ногоон, цэнхэр/
8. Тодруулагч /өнгийн/
9. Үдэгч
10. Үдэгчийн хадаас
11. Үдээс авагч
12. Хавтас бичгийн 2 хавчаартай
13. Хавтас бичгийн том /архив/
14. Хавтас бичгийн нимгэн
15. Хавтас бичгийн нимгэн /нүхтэй/
16. Хайч
17. Цаасны хавчаар /өнгөт/
18. Цавуу /20 гр/
19. Шингэн баллууур
20. Шугам

Багц 2:

Хэвлэгчийн хор -HP LaserJet 1010,1018,1020, canonLBP2900-**Q2612A**

Хэвлэгчийн хор -HP LaserJet P1005-**CB435A**

Хэвлэгчийн хор -HP LaserJet P1606dn-**CE278A**

Хэвлэгчийн хор -HP LaserJet P3015n-**CE255A**

Хэвлэгчийн хор -HP LaserJet M1212nf-**CE285A**

Хэвлэгчийн хор -Canon LBP 6030-**125, 325**

Хэвлэгчийн хор -Brother HL-2240D-**TN2215**

Хэвлэгчийн картридж-Brother HL-2240D-**Drum unit DR-2255**

Хэвлэгчийн хор -Panasonic KX-Panasonic KX-MB2030-**FAT411 A/E**

Хэвлэгчийн картридж -Panasonic KX-MB2030-**FAD412 A/E**

Хувилагч машины хор -Canon IR2018N-**NPG 28**

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Багц 1: Бичиг хэргийн материал

№	Бараа материалын нэр	Техникийн тодорхойлолт болон стандарт
1	Бал үзгэн /1,0/	✓ Чанартай /Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт/, ✓ Стандарт /Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалт/, ✓ Бараа бүтээгдэхүүн бүрийн үйлдвэрлэсэн улс, ✓ Бараа бүтээгдэхүүн бүрийн дээж, ✓ Бараа материалын нөөц болон татан авалт, хадгалалтын тухай дэлгэрэнгүй мэдээлэл,
2	Бал тосон /0,5/	
3	Бичгийн тавиур /босоо, төмөр/	
4	Бичгийн эрвээхэй хавчаар /том/	
5	Бичгийн эрвээхэй хавчаар /жижиг/	
6	Наадаг цаас /өнгөт/	
7	Өнгийн цаас /А4 ногоон, цэнхэр/	
8	Тодруулагч /өнгийн/	
9	Үдэгч	
10	Үдэгчийн хадаас	
11	Үдээс авагч	
12	Хавтас бичгийн 2 хавчаартай	
13	Хавтас бичгийн том /архив/	
14	Хавтас бичгийн нимгэн	
15	Хавтас бичгийн нимгэн /нүхтэй/	
16	Хайч	
17	Цаасны хавчаар /өнгөт/	
18	Цавуу /20 гр/	
19	Шингэн баллуур	
20	Шугам	

- 1. Стандарт:** Захиалагч холбогдох стандартыг заана. Эсхүл [Тухайн барааны гарал үүслийн улсын стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.] гэж бичнэ
- 2. Баглаа, боодол:** Стандартын шаардлага хангасан зориулалтын сав, баглаа боодолтой байна.
- 3. Бараа хүргэх газар:** Монгол Улс. 14201 Улаанбаатар хот. Төрийн ордон. Улсын Их Хурлын Тамгын газар.

Багц 2: Принтер болон хувилагчийн хор

№	Барааны нэр	Ашиглах төхөөрөмж	Хэвлэх өнгө	Хэвлэгчийн технологи	Тоо хэмжээ	Хэвлэх хэмжээ	Шаардлага
1	Хэвлэгчийн хор -Q2612A	HP LaserJet 1010,1018, 1020, canon LBP2900	Хар	Лазер	1ш	2.000 хуудас	1. Албан ёсны дистрибьютер байх, 2.Оргиналь үйлдвэрлэгчийн нууцлал бүхий лацтай байх, 3. Универсаль биш, тухайн хэвлэгчид зориулагдсан байх. 4.Баталгаат хугацаатай байх.
2	Хэвлэгчийн хор - CB435A	HP LaserJet P1005				1.500 хуудас	
3	Хэвлэгчийн хор - CE278A	HP LaserJet P1606dn				1.600 хуудас	
4	Хэвлэгчийн хор - CE255A	HP LaserJet P3015n				6.000 хуудас	
5	Хэвлэгчийн хор-TN2215	Brother HL-2240D				2.000 хуудас	
6	Хэвлэгчийн картридж - Drum unit DR-2255	Brother HL-2240D				12000 хуудас	
7	Хэвлэгчийн хор - CE285A	HP LaserJet M1212nf				1.600 хуудас	
8	Хэвлэгчийн хор – 125, 325	Canon I.BP 6030				1.600 хуудас	
9	Хэвлэгчийн хор - Panasonic KX- FAT411 A/E	Panasonic KX- MB2030	Хар	Лазер	1ш	2.000 хуудас	
10	Хэвлэгчийн картридж-KX-FAD412 A/E			Лазер	1ш	6.000 хуудас	

- 1. Стандарт:** Захиалагч холбогдох стандартыг заана. Эсхүл [Тухайн барааны гарал үүслийн улсын стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.] гэж бичнэ
- 2. Баглаа, боодол:** Стандартын шаардлага хангасан зориулалтын сав, баглаа боодолтой байна.
- 3. Бараа хүргэх газар:** Монгол Улс. 14201 Улаанбаатар хот. Төрийн ордон. Улсын Их Хурлын Тамгын газар.

Багц 1: Бараа нийлүүлэлтийн хуваарь

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Бичиг хэргийн материал	Бал үзгэн /1,0/	-	ширхэг	Төрийн ордон Улсын Их Хурлын Тамгын газар	-	-	
	Бал тосон /0,5/	-	ширхэг				
	Бичгийн тавиур /босоо, төмөр/	-	ширхэг				
	Бичгийн эрвээхэй хавчаар /том/	-	Хайрцаг				
	Бичгийн эрвээхэй хавчаар /жижиг/	-	хайрцаг				
	Наадаг цаас /өнгөт/	-	ширхэг				
	Өнгийн цаас /А4 ногоон, цэнхэр/	-	ширхэг				
	Тодруулагч /өнгийн/	-	ширхэг				
	Үдэгч	-	ширхэг				
	Үдэгчийн хадаас	-	ширхэг				
	Үдээс авагч	-	ширхэг				
	Хавтас бичгийн 2 хавчаартай	-	ширхэг				
	Хавтас бичгийн том /архив/	-	Ширхэг				
	Хавтас бичгийн нимгэн	-	Ширхэг				
	Хавтас бичгийн нимгэн /нүхтэй/	-	Ширхэг				
	Хайч	-	Ширхэг				
	Цаасны хавчаар /өнгөт/		хайрцаг				
	Цавуу /20 гр/		Ширхэг				
Шингэн баллуур		Ширхэг					
Шугам		Ширхэг					

Жич: Нийлүүлэгчээс ирүүлсэн үнийн саналыг үнэлж, гэрээ байгуулагдсан үед худалдан авалтын тоо хэмжээг захиалагчийн хүсэлтийн дагуу барааг нийлүүлнэ.

Багц 2: Бараа нийлүүлэлтийн хуваарь

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Багц 1	Хэвлэгчийн хор - HP LaserJet 1010,1018, 1020, canon LBP2900 - Q2612A	1	ширхэг	Төрийн ордон Улсын Их Хурлын Тамгын газар	2020.03 сар	-	
	Хэвлэгчийн хор - HP LaserJet P1005 - CB435A						
	Хэвлэгчийн хор - HP LaserJet P1606dn - CE278A						
	Хэвлэгчийн хор - HP LaserJet P3015n - CE255A						
	Хэвлэгчийн хор- Brother HL-2240D - TN2215						
	Хэвлэгчийн картридж - Brother HL- 2240D Drum unit DR-2255						
	Хэвлэгчийн хор - HP LaserJet M1212nf - CE285A						
	Хэвлэгчийн хор – Canon LBP 6030- 125, 325						
	Хэвлэгчийн хор - Panasonic KX- FAT411 A/E	1	ширхэг				
Хэвлэгчийн картридж-KX-FAD412 A/E							

Тав. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА**

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхой лолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ /бөөний үнэ/	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7
Тендерийн нийт үнэ						

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Зургаа. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших
1.1 Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт
1.1 Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх
3.1 Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх
4.1 Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа
5.1 Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах
6.1 Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр
7.1 Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш **ажлын 5** хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь
8.1 Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах
9.1 Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах
10.1 Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх
11.1 Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Долоо. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)**
- 1.1. Нийлүүлсэн бараа бүтээгдэхүүний сав баглаа боодол, чанарыг шалгаж акт үйлдэн хүлээн авна. Техникийн тодорхойлолтод заасан хэвлэх дардасны тоо хэмжээнд хүрэхгүй, чанарын шаардлага хангахгүй тохиолдолд бараа бүтээгдэхүүнийг буцаан солиулах эрхтэй.
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)**
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 3) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)**
- 3.1. Захиалагч нийлүүлсэн бараатай холбоотой санал гомдлоо нийлүүлэгч талд шуурхай мэдэгдэнэ.
- 3.2. Нийлүүлэгч дээрх мэдээллийг хүлээн аваад гэмтэлтэй барааг үнэ төлбөргүй шинэ бараагаар ажлын 5 хоногт багтааж сольж өгнө.
- 3.3. Нийлүүлэгчийн бараанаас болж хэвлэгч, хувилагчид гарсан хохиролыг нийлүүлэгч тал бүрэн хариуцна.
- 4. Төлбөр (ГЕН – 7)**
- 4.1. Захиалагч тал захиалсан бараа бүтээгдэхүүний төлбөрийн нэхэмжлэлийг нийлүүлэгч талаас хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан төлбөрийг шилжүүлж бараа бүтээгдэхүүнийг акт үйлдэн хүлээн авна.

Найм. ГЭРЭЭНИЙ МАЯГТ¹

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]**(цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

¹ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг²;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

² Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

**БИЧИГ ХЭРГИЙН МАТЕРИАЛ, ПРИНТЕРИЙН
БОЛОН ХУВИЛАХ МАШИНЫ ХОР НИЙЛҮҮЛЭХ
ҮНИЙН САНАЛ ХҮЛЭЭН АВСАН БҮРТГЭЛ**

№	Байгууллагын нэр	Албан тушаал, нэр, угас	Огноо, цаг	Гарын үсэг
1				
2				
3				
4				
5				
6				

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО